



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 14 өдөр


Дугаар А/103

Хужирт сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8.1, 9.8.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны "Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" А/370 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.
2. Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, яаралтай дархлаажуулалтад ажиллах хүч, шатахуун, бусад холбогдох зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дархлаажуулалтын ажлыг товлосон хугацаанд үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг Ажлыг хэсэг (Б.Ичинхоролцэвэлмаа), малчин, мал бүхий иргэдэд мэдээлж, малыг бүрэн хамруулахад анхаарч ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Дархлаажуулалтад шаардагдах зардлыг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.
5. Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хяналт тавьж ажиллаж, үр дүнг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.



ОРЛОГЧ

Б.ДЭМБЭРЭЛ